

**ЗАЛУУЧУУДЫН ТАЛААР БАРИМТЛАХ ТӨРИЙН БОДЛОГОД
ХИЙСЭН БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ****С.МӨНХБАТ**

Доктор, дэд проф. МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар.

Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч

Б.БАТ-ЭРДЭНЭ

Докторант

Түлхүүр үг: Ралуучууд, насны бүтэц, төрийн бодлого, нийгэм эдийн засгийн нөхцөл, эдийн засгийн бодлого, амьдрах орчны нөхцөл, ажилгүйдэл, ажил эрхлэлт.

Abstract: So many countries processed and implemented of the state policy on youth in the world. Because, the youth are the future of every nation. Therefore, any state policy has been active for many young people. These, to belong economic, social, education, health and political participation policy.

In this research article, we have analysis the Mongolian government's economic and social policy for youth people and its implementation.

УДИРТГАЛ

Залуучуудын талаарх төрийн бодлогын шинжилгээний ерөнхий тойм

Өнөөдөр Монгол улсын нийт хүн ам 3 сая болж 2015 онтой золгож байна. Монголын нийт хүн амын 10 орчим хувийг ахмад настнууд, 27,7 хувийг 0-14 насны хүүхэд, 37,5 хувийг 15-34 насны өсвөр үе, залуучууд, 51 хувийг эмэгтэйчүүд, 49 хувийг эрэгтэйчүүд эзэлж, улсын хэмжээнд 768 мянга 263 өрх, гэр бүл аж төрж байна. Манай улсын хүн амын гуравны нэгээс илүү хувийг 18 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байна. Нийт хүн амын 40 орчим хувийг 18 хүртэлх насны, 13 орчим хувийг 19-24 насны залуучууд эзэлдэг¹. Манай улсын 5 хүн тутмын нэг нь 15-24 насны залуучууд, нийт хүн амын 37.5 хувийг 15-34 насныхан эзэлж байна. Үүнээс үзэхэд Монгол улс бол идэр насжилттай залуучуудын орон юм.

Монгол улсын засгийн газраас Залуучуудын үндэсний хөтөлбөрийг 1998-2005 онд батлан хоёр үе шаттайгаар хэрэгжүүлж, хөтөлбөрийн хүрээнд залуучуудын эрүүл мэндийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чөлөөт цагийг зөв боловсон, үр бүтээлтэй өнгөрүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэхэд анхаарч ирсэн байдаг. Түүнчлэн 2006 оноос “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байгаа ба Залуучуудын хөгжлийн талаар баримтлах шинэчлэлийн бодлого, зорилгоо тэдний оролцоотой тодорхойлох зорилгоор гурван үе шаттай (1-р шат 2007-2008, 2-р шат 2009-2012, 3-р шат 2013-2015) арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. 2013 онд “Өсвөр үеийнхний хөгжлийн форум 2013” болон “Залуучуудын хөгжил-шинэчлэлийн бодлого, зорилг” үндэсний чуулганыг зохион байгуулсан. Залуучуудын чуулганыг угтан “Залуучуудын хөгжилд хамтдаа” сарын аяны хүрээнд залуучуудын хөгжлийн асуудлаарх салбар дундын оролцоо, хамтын ажиллагааг бий болгох, харилцан мэдээлэл солилцох, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах зорилго бүхий хэлэлцүүлгүүдийг тус тус зохион байгуулж байжээ.

Залуучуудын асуудлаар төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагаанд хийх дүн шинжилгээ бол нэгдмэл шинжтэй нийгэм, эдийн засаг, улс төр болон хүн амыг хамарсан өргөн хүрээтэй, цогц үйл явц юм. Тиймээс энэ удаагийн залуучуудын асуудлаар хийж буй бодлогын судалгааг хэд хэдэн бүрэлдэхүүн хэсэгт хуваан авч үзсэн. Эдгээрийг дурдвал:

I) Залуучуудын талаарх төрийн бодлогын шинжилгээний зорилго, арга зүй

II) Залуучуудын эдийн засаг, амьдрах орчны бодлогын шинжилгээ

III) Залуучуудын нийгэм, соёлын бодлогын хэрэгжилтэд хийсэн шинжилгээ

IV) Залуучуудын улс төрийн оролцоо, төрийн болон төрийн бус байгууллагуудын бодлогын хэрэгжилтэд хийсэн шинжилгээ хэмээн хийлээ.

¹ ХАХНХЯ-ны ажлын тайлан. УБ., 2013

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлдээ эхний хоёр хэсэг буюу залуучуудын талаарх төрийн бодлогын шинжилгээний зорилго, арга зүй болон залуучуудын эдийн засаг, амьдрах орчны бодлогын шинжилгээг багтаалаа. Дараагийн удаа залуучуудын нийгэм, соёлын бодлогын хэрэгжилтэнд хийсэн шинжилгээ болон улс төрийн оролцоо, төрийн болон төрийн бус байгууллагуудын бодлогын хэрэгжилтэд хийсэн шинжилгээг цуврал байдлаар толилуулахаар бэлтгэж байна.

НЭГ, ЗАЛУУЧУУДЫН ТАЛААРХ ТӨРИЙН БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

1. Бодлогын шинжилгээний зорилго, зорилт


Залуучуудын талаар төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагаанд хийж буй бодлогын судалгааны үндсэн зорилго бол төрийн бодлого хөтөлбөр, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх замаар өнөөгийн залуучуудын сонирхол, хэрэгцээнд нийцсэн бодлогын оновчтой хувилбарыг дэвшүүлэх явдал хэмээн үзэж байна. Иймд бодлогын дүн шинжилгээний хүрээнд дараах нийтлэг зорилтуудыг дэвшүүлээ.

- Залуучуудад тулгамдаж буй бодлогын асуудлын хүрээг судалгаанд суурилан бодитой, ойлгомжтой тодорхойлох
- Өнөөгийн төрийн бодлого, үйл ажиллагааг баримт материалд тулгуурлан тоймлох, тайлбарлах
- Бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг үнэлэх, залуучуудын асуудлаар бодлогын боломжит хувилбаруудыг дэвшүүлэн гаргах
- Залуучуудын талаар баримтлах төрийн бодлогыг сайжруулах, илүү оновчтой болгоход чиглэсэн тодорхой алхмуудыг санал болгох зэрэг болно.

2. Бодлогын шинжилгээ хийх арга зүй, аргачлал

Залуучуудын асуудлаар төрөөс баримталж буй бодлогод дүн шинжилгээ хийхдээ бүтэц үүргийн (structure-functionalist) хандлагыг гол арга зүй болгосон. Чингэхдээ залуучуудад тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийж, эдгээрт төр засаг, нам улс төр, иргэний нийгэм, олон нийтийн байгууллага, институцийн гүйцэтгэж буй үүрэг, үйл ажиллагааны байдалд дүн шинжилгээ хийх замаар хэрэгжилт үр дүнг үнэлсэн болно.

Зураг 1.1 Бодлогын дүн шинжилгээ хийх арга зүй: Бүтэц, үүргийн хандлага



3. Бодлогын шинжилгээний түвшин:

Залуучуудын бодлогын шинжилгээг төр засгийн байгууллага, нам улс төрийн хүчин, иргэний нийгэм, олон нийтийн байгууллага зэрэг институцийн түвшинд авч үзлээ. Төр засгийн байгууллагаас гаргасан хууль тогтоомж, шийдвэр, институт, бодлого үйл ажиллагаа, нам улс төрийн хүчний хөтөлбөр, бодлогын баримт бичиг, иргэний нийгэм олон нийтийн байгууллагын судалгаа, үнэлгээ зэргийг асуудлыг шинжлэх хүрээнд авч үзэж судалсан.

4. Бодлогын шинжилгээний хэрэгжилтийн үнэлгээ:

Бодлогын шинжилгээний хүрээнд залуучуудын асуудлаар төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийг зорилго, зорилт, үр дүн, үр нөлөө, ач холбогдол, сургамж зэрэг хүчин зүйлд хуваан шинжилгээ хийсэн. Эдгээр хүчин зүйлийг түгээмэл аргачлал, нийтлэг загвар болох бодлого шийдвэр, төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааг үнэлэх гүйцэтгэлийн хэмжүүр үзүүлэлт(S.M.A.R.T загвар)-эд тулгуурлан авч үзлээ. Үүнд:

- Тухайлсан(specific)-аль нэг бодлогын үзүүлэлт нь бүхэл бүтэн зүйлийн нэг чиг үүрэг буюу талыг нэг л төлөвөөс нь илэрхийлэх.
- Хэмжигдэхүйц(measurable)-үзүүлэлт хэмжиж болохуйц нөхцөлтэй байх.
- Бололцоотой (achievable)-үзүүлэлт байгаа бололцоо, нөхцлийн хүрээнд хүрч болохуйц зүйлийг гаргах.
- Үр дүнд чиглэсэн(result-focused)- Зорилго нь үйлдэл бус, үр дүнд чиглэсэн байх.
- Цаг үеэ олсон(Time-bound)-тухайн цаг хугацаанд нэн тэргүүний зүйлийг тусгана.

5. Бодлогын шинжилгээний үе шат

Залуучуудын асуудлаар төрөөс баримталж буй бодлогод хийсэн энэхүү дүн шинжилгээний ажлыг доорх үе шатуудад хуваан, хийсэн болно.

Залуучуудын асуудлаар хийсэн бодлогын шинжилгээний үе шат

Хүснэгт 1.1

1.Шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тодорхойлох	Залуучуудын эдийн засаг, нийгэм соёл, улс төр, эрхийн тулгамдсан асуудлууд
2. Төрийн бодлогын хэрэгжилтэд үнэлгээ өгөх	Залуучуудын талаар хэрэгжүүлж буй төрийн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн
3. Асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлогын хувилбарууд	Залуучуудын талаар авч хэрэгжүүлэх оновчтой бодлого, хөтөлбөр
4. Бодлогохэрэгжүүлэх үйл явц	Бодлогыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын эрх, үүрэг, байр суурь

Залуучуудын хөтөлбөрийн үнэлгээний тайлангаас үзэхэд 1998-2005 онд хэрэгжүүлсэн Монголын залуучуудын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 80 хувьтай байжээ². Харин үүнээс хойш 2006-2015 он хүртэл хэрэгжүүлж байгаа “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн үр дүн, нөлөөг харахан үнэлээгүй байна.Монгол улсад боловсрол, соёл, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд зэрэг чиглэлүүдээр хүн амтай холбоотой нийгмийн асуудлыг хариуцаж үйл ажиллагаа явуулдаг төр засгийн болон иргэний нийгмийн дараах байгууллага, институцүүд ажиллаж байна. Үүнд:

²Залуучуудын бодлогын хэрэгжилтийн үнэлгээний тайлан, 3-6, 2005

б. Залуучуудын чиглэлээр ажиглаж буй төрийн байгууллага, институтууд

Хүснэгт 1.2

№	Төр засгийн байгууллага, институт	Харуцаж буй бодлого, хөтөлбөр
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	"Засгийн үүр" хөтөлбөр
2	Боловсрол, шинжлэх ухааны яам	Сургалт, мэргэжлийн боловсрол сургалт, шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр
3	Соёл, спорт аялал жуулчлалын яам	Өв уламжаалыг хадгалах дамжуулах, соёл урлаг хөгжүүлэх төсөл хөтөлбөр
4	Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалтын яам	Монгол Улсын хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын төрөөс гэр бүлийн талаар баримтлах бодлого, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр, Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр
5	Хөдөлмөрийн яам	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Оюутны цагийн хөдөлмөр эрхлэлт, Хөдөлмөрийн бирж
6	Эрүүл мэндийн яам	Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл амьдрах хэв маяг, зан үйлийг бий болгох, нөхөн үржихүйн эрүүл мэнд, БЗХӨ, ДОХ-той тэмцэх төсөл, хөтөлбөр
7	Хүний хөгжил сан	Монгол Улсыг хөгжүүлэх сан, эх хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тэтгэмж олгох, залуу гэр бүл, шинээр төрсөн хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж
8	Орон нутгийн нийгмийн бодлогын газар, хэлтэс	Залуучуудын боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, соёл урлаг, сургалт, орломог дэмжих

Улс төрийн намын дэргэдэх болон иргэний нийгэм, олон улсын залуучуудын байгууллага

Хүснэгт 1.3

Залуучуудын байгууллага	Гишүүнчлэл
МҮЭ-ийн дэргэдэх залуучуудын байгууллага	∞ 100000 гаруй
Монголын залуучуудын холбоо	∞ 100000
Нийгмийн Ардчилал Монголын залуучуудын холбоо	∞ 70000
Ардчилсан залуучуудын холбоо	∞ 60000 гаруй
Монголын оюутны холбоо	∞ 150000
Монголын скаутын холбоо	∞ 10000
Нийгмийн Ардчилал Монголын оюутны холбоо	∞ 50000
Аймаг, орон нутгийн оюутан залуучуудын байгууллага	∞ 40000 орчим
Анагаахын залуу судлаачдын холбоо	∞ 1000
Залуу үе танхим JCI	∞ 400
НҮБ-ын дэргэдэх залуучуудын байгууллага	∞ 100

ХОЁР, ЗАЛУУЧУУДЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ ЭДИЙН ЗАСАГ, АМЬДРАХ ОРЧНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛГЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Залуучуудын талаар төрөөс баримталж буй эдийн засгийн бодлого, амьдрах орчны шинжилгээг дараах чиглэлүүдээр хийлээ.

- а) орлого, амьжиргааны эх үүсвэр.
- б) хөдөлмөр эрхлэлт.
- в) амьдрах орчин.
- г) сууцны нөхцөл.
- д) залуучуудыг дэмжих эдийн засгийн үйл ажиллагаа зэрэг болно. Ингээд сэдэв тус бүрээр өнөөгийн залуучуудад тулгамдаж буй асуудал, залуучуудын талаар баримталж буй бодлого, үйл ажиллагааг дэлгэрүүлэн авч үзье.

2.1 Залуучуудын орлого, амьжиргааны эх үүсвэр

Амьжиргааны түвшин, орлого зэрэг эдийн засгийн байдлын хувьд хамгийн их гадуурхагдсан, баялгийн хуваарилалтаас хоцорсон бүлэг бол тэтгэвэрийн насныхан хийгээд амьдралд дөнгөж хөл тавьж байгаа залуучууд болох нь олон тооны суурь судалгааны дүнгээр батлагдаж байна. Зах зээлийн нийгэмд шилжих үеийн эдийн засгийн хямрал, орлогын тэгш бус хуваарилалтад өртсөн бүлэг бол залуучууд, түүнчлэн ажилгүйдлийн эгнээнд олноор түрэн орогсад, шилжилтийн үеийн "архаг ядуурал"(ушмал ядуурал)-ыг өвлөн авагсад нь мөн л залуучуудын бүлэг билээ. Үүнийг бататгахын тулд дараах судалгааны дүнгүүдтэй¹ танилцъя.

¹Монголын залуучуудын хөгжлийн хэрэгцээ суурь судалгааны тайлан МЗХ-ны Полис төв (2002-2003) Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого сэдэвт суурьсудалгааны дүн. НАМЗХ, Социологийн боловсрол төв. УБ, 2013 он Залуучуудын улс төр, нийгмийн оролцоо сэдэвт судалгаа. ШУА ФСЭХ УБ, 2014

1. Өнөөгийн Монголын залуучуудын мөнгөн орлого хомс, хэрэгцээгээ хангах байдал хязгаарлагдмал байна. Нийт залуу өрхийн 54.1% нь өдөр тутмын хооллох, хувцаслах хэрэгцээгээ хангах төдийгөөр “тарчигхан” байдалтай амьдарч байгаа юм.

ХҮСНЭГТ 2.1 ӨРХИЙН ОРЛОГЫН ХҮРЭЛЦЭЭ

	Давтамж	Хүчинтэй хувь
1 Өдөр тутмын ойр зуурын хэрэгцээнд ч хүрэлцдэггүй	235	13.4
2 Өдөр тутмын хэрэгцээгээ л хангадаг	712	40.7
3 Өдөр тутмын хэрэгцээгээ хангаж, дээр нь хэрэгцээт зүйлсээ авчихдаг	621	35.5
4 Тэдгээрээс гадна үнэ цэнэтэй зүйлийг авчихдаг	85	4.9
5 Хүссэн зүйлээ авч чаддаг	96	5.5
6 НИЙТ	1749	100.0
7 Хариулаагүй	51	
НИЙТ	1800	

ХҮСНЭГТ 2.2 АМЬЖИРГААНЫ ТҮВШИН

	ДАВТАМЖ	ХУВЬ
1 МАШ МУУ	5	.3
2 МУУ	64	3.7
3 ДУНД ЗЭРЭГ	748	43.4
4 САЙН	747	43.4
5 МАШ САЙН	158	9.2
НИЙТ	1722	100.0

2. Залуучуудын орлогын эх үүсвэрийг зонхилон цалин бүрдүүлж байна.

Залуучуудын бодит цалингийн хэмжээ бага байгаагийн дээр өрхийн орлогод цалин голлож байгаа нь өнөөгийн залуучууд санхүүгийн эмзэг байдлыг илтгэх үзүүлэлт мөн. Үүний зэрэгцээ зөвхөн хүүхдийн тэтгэмжээр(11.1%), тэтгэмж, эцэг эхийн тэтгэвэрээр(7.6%), хамаатан садны дэмжлэг туслалцаагаар(5.1%) амьдарч байгаагаа залуучууд илэрхийлсэн байна.

ХҮСНЭГТ 2.3 ЗАЛУУ ӨРХИЙН ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР

Орлогын төрөл	Давтамж	Хувь
1 Цалин	1414	49.7%
2 Бизнес, наймааны орлого	394	13.9%
3 Хүүхдийн тэтгэмж	316	11.1%
4 Тэтгэмж, эцэг эхийн тэтгэвэр	216	7.6%
5 Өрхийн аж ахуй\мал, ногоо, туслах аж ахуй\	178	6.3%
6 Хамаатан садны дэмжлэг туслалцаа	145	5.1%
7 Түрээсийн ашиг	86	3.0%
8 Зээл болон хадгаламжийн хүүгийн орлого	67	2.4%
9 Мөнгөн тусламж	27	0.9%
НИЙТ	2843	100.0%

Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого сэдэвт суурь судалгааны дүн. НАМЗХ. Социологийн боловсрол төв. УБ., 2013 он

Залуучуудын үлэ төр, нийгмийн орлоцоо сэдэвт судалгаа. ШУА.ФСЭХ. УБ., 2014

3 Залуучуудын хөдөлмөрийн үнэлгээ ялгавартай, цалин орлого харьцангуй бага байна.

Суурь судалгааны дүнгээс үзэхэд⁴ өнөөгийн залуучуудын бараг тал хувь(49.9%) нь500 мянга хүртэлх төгрөгийн орлоготой, залуу өрхийн аль нэг гишүүн ажил эрхлэн(74.5%) амьдарч байна. Хот хөдөөгөөр харьцуулан залуучуудын ажилгүйдлийн шалтгааныг авч үзвэл хөдөөд ажлын байрны хүрэлцээ муу, хотод мэргэжлээрээ ажиллах боломж хомс, хөдөлмөрийн цалин урамшуулал бага, хөдөлмөрийн нөхцөл муу байгаагаас залуучууд ажилгүйдэлд өртөж байна. Мөн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, их, дээд сургуулиудын мэргэжилтэн бэлтгэж буй хөтөлбөрийн уялдаа муу байгаа нь нэг нөлөөлөх хүчин зүйл болсоор байна.

ХҮСНЭГТ 2.4 ЗАЛУУЧУУДЫН АЖИЛГҮЙДЛИЙН ШАЛТГААН⁵

№	Шалтгаан	Хот	Хөдөө
1	Ажлын байр хомс	30.4%	36.0%
2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хангалтгүй	9.3%	11.6%
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тал дээр төрөөс анхаардаггүй	11.5%	16.4%
4	Цалин хөлс бага	9.9%	10.6%
5	Хувь хүний идэвхигүй байдал, залуурал	22.5%	17.9%
6	Бэлэнчлэх сэтгэлгээ	13.5%	5.3%
7	Ажлын хүндээс шантардаг	2.8%	2.3%

2.2 Залуучуудын хөдөлмөр эрхлэлт

Монгол Улсын хүн амын дийлэнх нь залуучууд бөгөөд жил бүр залуучуудын эгнээнд олон тооны хүмүүс нэгдэн орж байгаатай холбогдуулан залуучуудын хөдөлмөр эрхлэлт өнөөгийн тулгамдсан, үндсэн асуудлын нэг болж байна. Жил бүрийн статистик мэдээг харьцуулан үзвэл Хөдөлмөр эрхлээгүй хүн амын 60-70 хувь нь залуучууд бөгөөд жил тутам 50-60 мянган залуучууд хөдөлмөрийн насанд шилждэг боловч тэдгээрийн багадаа 50 хүртэл, ихдээ 60 гаруй хувь нь эрхэлсэн ажил, сургуульгүй үлддэг байна.

1.Залуучуудын дунд хөдөлмөр эрхлэх идэвхи сул, ажиггүйдлийн түвшин өндөр байна.

ХҮСНЭГТ 2.5 ЗАЛУУЧУУДЫН АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН

	Ажиллах хүчний оролцооны түвшин	Ажилгүйдлийн түвшин	Ажил эрхлэлтийн түвшин	Идэвхгүй байдлын түвшин
Боловсролгүй	57.9	8.1	53.3	42.1
Бага	50.2	7.7	46.3	49.8
Бүрэн бус дунд \8-р анги төгссөн\	26.2	14.9	22.3	73.8
Бүрэн дунд \10-р анги төгссөн\	28.4	21.9	22.2	71.6
Техник, мэргэжлийн	65.4	15.3	55.4	34.5
Тусгай мэргэжлийн дунд	67.8	8.1	62.3	32.2
Бакалаврын зэрэгтэй дээд	77.5	11.6	68.5	22.5
Магистр ба түүнээс дээш зэрэгтэй	79.2	5.4	74.9	20.8
Бүгд	39.7	14.0	34.2	60.2

Эх сурвалж: Франческо Пастер. Сургуулиас ижилд шилжихсдийн судалгаа. ОУХБ-2007

⁴Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого сэдэвт суурьсудалгааны дүн, НАМЭХ. Социологийн боловсрол төв. УБ., 2013 он

⁵ ШУА,ФСЭЭХ. Залуучуудын амьдралын зорилго, үнэт чанарын өөрчлөлт. Судалгааны нэглсэн дүн-2010

Судалгааны дээрх дүнгээс үзэхэд хөдөлмөрийн зах зээлд ажиллаж буй залуучуудын мэргэжлийн болон дээд боловсролын үнэлэмж хандлагын ялгаанаас хамааран эрхэлж буй ажлын нэр хүнд, хөдөлмөрийн үнэлгээний зааг ялгаа их байна. Залууст мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын хэрэгцээ үгүйлэгдэж байна. Монголын залуучуудын гадаадад хөдөлмөр эрхлэх сэдэл, хандлага түгээмэл хэвээр байна. Дотоодын шилжинги чанартай хөдөлмөр эрхлэлт залуу гэр бүлд хохирол учруулсаар байна.

2.3 Залуучуудын сууцны нөхцөл

Монголын залуучуудад тулгамдаж буй үндсэн асуудлын нэг бол амьдран суух орон сууцны асуудал юм. Өнөөгийн залуучуудын сууцны нөхцөл хот хөдөөд харилцан адилгүй байна. Залуучуудын амьдрах сууцны нөхцлийг судалсан судалгааны дүнгээс үзэхэд 10 залуу хүн тутмын нэг нь түрээсийн байранд, мөн тэр хэмжээний залуучууд бусдын сууцанд түр хугацаанд амьдардаг дүн мэдээ байна. Өнөөдөр залуучуудын асуудлыг шийдвэрлэх төрөөс баримтлах гол чиглэл бол тэдгээрийн сууцны асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх явдал мөн. Залуучуудыг өөрийн орон сууцтай болохыг дэмжсэн оновчтой хувилбар бүхий хэд хэдэн үе шат бий.

Үе шатууд	Төрийн үе шаттай дэмжлэгүүд
Үе шат 1	Төрийн дэмжлэгээр баригдсан нийтийн сууцнуудад хэдэн сарын хугацаанд үнэ төлбөргүй амьдрах
Үе шат 2	Тодорхой ажил, хөдөлмөртэй болох үед хямд үнэтэй түрээсийн байрлуу шилжих
Үе шат 3	Залууст зориулсан хямд үнэтэй нэг, хоёр өрөө байрнуудыг түрээслэх боломжоор хангах
Үе шат 4	Хуримтлал үүсгэн бага хэмжээний талбай бүхий, залуучуудад зориулсан, зөв төлөвлөлттэй орон сууцыг худалдан авах
Үе шат 5	Тодорхой мөнгөн хуримтлалтай болж, хүссэн байр, сууцаа худалдан авах

2.4 Залуучуудыг дэмжих буй эдийн засгийн бодлого, үйл ажиллагаа

Залуучуудыг дэмжих эдийн засгийн тусгайлсан арга хэмжээ байхгүй боловч төрийн бодлогын зарим хэсэгт тусгагдан шийдвэрлэгдэж байсан юм. Сонгуулийн зарим популист амлалттай холбоотойгоор нийт хүн амд олгох мөнгөн дэмжлэг, тусалцаа шинээр гэрлэгдэд 500 мянган төгрөг, шинээр төрсөн хүүхдэд 100 мянган төгрөг олгож байна. Үүнээс өөр зорилтот бодлого өнөө хэр үгүйлэгдсээр байна.

ТОВЧ ДҮГНЭЛТ

Өнөөгийн залуучуудын эдийн засаг, амьдрах орчны баталгааг төр засгаас хангах бодлогын хэрэгжилт тааруу, үр дүн муутай байгаа нь бодлогын шинжилгээний үр дүнгээс харагдаж байна. Бодлогын хэрэгжилтийг үнэлэх шинжилгээний хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Залуучууд амьжиргааны түвшин, эдийн засгийн байдлын хувьд хүн амын бүлгийн дотор нэлээд доогуур түвшинд орж байгаа нь тэднийг эмзэг байдалд түлхэн оруулах үндсэн хүчин зүйл болж байна.
- Өнөөгийн залуучуудын талаас илүү хувь нь өдөр тутмын хооллох, хувцаслах хэрэгцээнээс илүү гарч чадахгүй байгаа явдал бол залуучуудын амьжиргаа тааруу, хэрэгцээ хангалт “тарчигхан”, эдийн засгийн агуулгаар ядуурлын нөхцөлд байна.
- Залуучуудын өрхийн орлогод цалин гол эх үүсвэр болж байгаагийн зэрэгцээ цалингийн хэмжээ бага байгаа нь өнөөгийн залуучууд болон залуу өрхийг санхүүгийн эмзэг байдалд оруулахад нөлөө үзүүлж байна.
- Хөдөлмөр эрхлэх эсэх нь өнөөгийн залуучуудын эрх хэмээн орхиж болохгүй бөгөөд, өнөөгийн залуучуудын дунд байгаа ажилгүйдэл бол хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй

мэргэжилтэн болон боловсролын байгууллагаас бэлтгэж буй мэдлэг чадвар муутай боловсон хүчин хоорондын эрэлт нийлүүлэлтийн харьцаа алдагдсаныг үр дүн мөн.

- Залуучуудын ажилгүйдэл, олоогийн олж буй цалин орлого бага болон эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамжгүй байгаа явдал нь тэднийг гадаадад хөдөлмөр эрхлэх үндсэн шалтгаан болж байна. Гадаадад хөдөлмөр эрхлэх нь цалин орлогоо нэмэгдүүлэх бодит боломж хэдий ч, залуучуудын эрүүл мэнд, аюул осолгүй нөхцөлд ажил эрхлэх зэрэг эрхийг ноцтой зөрчиж байна. Энэ нөхцөл байдал дотоодын барилга болон уул уурхайн салбарт мөн тохиолдож байна.
- Өрх бүлээс өөр газарт ажиллаж, амьдарч байгаа залуу өрхийн хувьд гэр бүлийн харилцаа хөндийрөх, тусдаа амьдрах, гэр бүл салах зэрэг олон тооны сөрөг үзэгдэлтэй тулгарч, хохирч байна.
- Залуучуудын нэлээдгүй хувь нь эцэг эхийн хамт, бусдын сууцанд түр хугацаагаар, эсвэл түрээсийн байранд амьдарч байгаа нь төрөөс залуучуудын амьдрах сууцны асуудлыг оновчтой хувилбараар, үе шаттайгаар нэн түрүүнд шийдвэрлэх шаардлагатай болохыг харуулж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Азийн барометр. Ред Д.Ганбат, У., 2008
2. Ардчилал ба улс төрийн нам. Онол, практикийн бага хурлын эмхэтгэл. МАН. УБ., 2009
3. БСШУЯ. Монголын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө
4. Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи. Асуудал, аргачлал, ашиг тус. УБ., 2013
5. Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого сэдэвт суурь судалгааны дүнгээс. НАМЗХ, Социологийн боловсрол төв, УБ., 2013 он
6. Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр. МУЗГ. 2006-282 тогтоолын хавсралт
7. Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага судалгааны тайлангаас. МУ-ын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Азийн хөгжлийн банк, УБ 2010 он
8. Монгол улсын Үндсэн хууль., 1992
9. Монголын ардчиллын төлөвшил. ШУА. ФСЭХ хамтын бүтээл. УБ., 2011
10. Монголын залуучуудын нийгмийн төрх (XX-XXI зууны зааг дээр). ШУА. ФСЭХ. УБ., 2012
11. Монгол дахь ардчиллын хөгжил: сорилт, боломж. Үндэсний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ., 2005
12. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик. ЭШ-ний бага хурлын эмхэтгэл. УБ., 2009
13. Монгол дахь социологийн хөгжил. ШУА. ФСЭХ хамтын бүтээл. УБ., 2011
14. Монгол улс дахь иргэний нийгмийн төлөвшил. Социологийн судалгааны тайлан. ШУА. ФСЭХ хамтын бүтээл. УБ., 2013
15. Монгол улсын эрүүл мэндийн алба: 80 жил, ЭМЯ, 2001
16. Монголын засаглалын үзүүлэлтүүд. ШУА. ФСЭХ. УБ., 2013
17. Монголын залуучуудын хөгжлийн хэрэгцээ; суурь судалгааны тайлан МЗХ-ны Полиси төв (2002-2003)
18. Монголын нийгмийн өөрчлөлт. Хамтын бүтээл. Ред. Б.Даш-Ёндон. УБ 2009. 208 дахь тал
19. Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага судалгааны тайлангаас. МУ-ын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Азийн хөгжлийн банк, УБ 2010 он
20. Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. Социологийн судалгааны тайлан. НҮБХАС. НХХЯ. ФСЭХ. 2010. 57 дахь тал
21. Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар. Судалгааны тайлан. УБ.2005
22. Нийгмийн харилцааны өөрчлөлт шинэчлэлт, Судалгааны тайлан. МУИС. 2009
23. НХХЯ. Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал суурь судалгаа. 2004

24. НХХЯ. Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал суурь судалгаа. 2004
25. ХАХНХЯ-ны 2013 оны ажлын тайлан
26. Хүмүүс: улс төр-нийгмийн амьдрал сэдэвт суурь судалгаанууд. Нийгмийн Ардчиллын Хүрээлэн. 2011, 2012, 2013
27. Улс төрийн барометр. Социологийн судалгаа, Сант Марал судалгааны төв, УБ., 2008 оны 4-р сар
28. Г.Чулуунбаатар. XIX, XX зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт. УБ., 2008
29. ШУА.ФСЭЗХ. Залуучуудын амьдралын зорилго, үнэт чанарын өөрчлөлт. Судалгааны нэгдсэн дүн-2010
30. International Encyclopedia of Political Science, Sage., 2012
31. Prohl W. Sumati L. Voter's Voices. UB., 2008